



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/404

Булган сум

### Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалт, Засгийн газрын 2025 оны 121 дүгээр тогтоолоор баталсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Б.Батчимэг (ГЮ90041728)-ийн Булган сум 6 дугаар баг Залуус 7 дугаар гудамж 702 тоотод байршилтай 6308002732 нэгж талбар бүхий амины орон сууц зориулалтаар эзэмшиж буй 773 м<sup>2</sup> газрын газар эзэмших эрхийг Б.Галтсүрэн (ГА93081518)-д шилжүүлэн 13 жилийн хугацаатай, “Дэвшилтэд” ХХК (РД:2007282)-ийн Булган сум 5 дугаар баг Хатанбаатар С.Магсаржав 2 дугаар гудамж 2136 тоотод байршилтай 6308009707 нэгж талбар бүхий нийтийн орон сууц зориулалтаар эзэмшиж буй 3903 м<sup>2</sup> газрын газар эзэмших эрхийг Р.Оюун-Эрдэнэ (ГЮ69112567)-д шилжүүлэн 12 жилийн хугацаатай тус тус эзэмшүүлсүгэй.

2. Б.Галтсүрэн, Р.Оюун-Эрдэнэ нартай газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасгай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны А/818 дугаар захирамжийн Б.Батчимэг, 2024 оны А/193 дугаар захирамжийн “Дэвшилтэд” ХХК-тай холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР